# “ СУВИЛАГЧ МЭРГЭЖИЛТНИЙ УР ЧАДВАРЫН  ШАТЛАЛ”-ЫГ АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА

**2024 он**

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 15 өдөр Дугаар А/69 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.1.9.6, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.4, 1, 3.47, 2021 оны А/26 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6 дахь заалтыг тус тус үндэслэн Тушаах нь

1. Сувилахуйн эмнэл зүйн ур чадварын шатлал болон шинэ төгссөн сувилагчийн сургалтын удирдамж боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Сувилахуйн эмнэл зүйн ур чадварын шатлал болон шинэ төгссөн сувилагчийн сургалтын удирдамжийг Японы олон улсын хамтын байгууллага (ЖАЙКА)-тай хамтран боловсруулж, төслийг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хуралд танилцуулж, хэлэлцүүлэхийг Эрүүл мэндийн эдийн засаг, бодлогын судалгааны албаны дарга, Хүний нөөцийн хөгжлийн албаны даргын үүргийг хавсран гүйцэтгэгч (Б.Отгончимэг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүү удирдлагын алба (Л.Оюунчимэг)-т даалгасугай.

ЗАХИРАЛ Б.НАРАНТУЯА

132300000

мэндийн хөгжлийн төвийн
лын 2023 оны 08 дугаар сарын 18
н А/69 дугаар тушаалын нэгдүгээр
элт

УХА0456 9086331

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга: Б.Отгончимэг, Эрүүл мэндийн хөгжлийн тевийн Эруул мэндийн эдийн засаг, бодлогын судалгааны албаны дарга, Хүний нөөцийн хөгжлийн албаны даргьн үүргийг хавсран гуйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: У.Наранцэцэг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хуний нөөцийн хөгжлийн албаны сувилагч, тусгай мэргэжилтний сургалт, хөгжил хариуцсан мэргэжилтэн

## 1. Сувилахуйн эмнэл зуйн ур чадварын шатлалыг боловсруулах ажлын хэсгийн гишууд:

Ц.Хандармаа, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн Сувилахуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Г.Хулан, Эруул мэндийн яамны дэргэдэх Сувилахуйн салбар зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр)

Д.Энхтуяа, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Мэргэжил дээшлуулэх институтийн сувилахуйн сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Цэгмид, Улсьн нэгдүгээр төв эмнэлгийн Сувилахуйн албаны арга зуйч

Д. Нацагсурэн, Улсьн хоёрдугаар төв эмнэлгийн Сувилахуйн албаны дарга

М.Мөнх-Эрдэнэ, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасгийн сувилагч

Д. Тунгаамаа, Улсын гуравдугаар төв эмнэлгийн Сувилахуйн асуудал эрхэлсэн дэд захирал

Б.Эрдэнэцэцэг, Орхон аймгийн Бусийн оношилгоо, эмчилгээний төвийн Сургалтын албаны арга зуйч

Ч. Тунгалаг, Орхон аймгийн Үйлс бадрах өрхийн эрүүл мэндийн төвийн арга зуйч

А.Амарцэнгэл, Сухбаатар дүүргийн эрүүл мэндийн төвийн Сувилахуйн албаны дарга

Л.Амаржаргал, Монголын сувилахуйн нийгэмлэгийн гишуун

2. Шинэ сувилагчийн сургалтын удирдамж боловсруулах ажльн хэсгийн гишүүд:

Б. Уянга, Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрьн Хүний нөөцийн мэргэшил, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Б.Оюунгоо, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн захирал (зөвшилцсөнөөр)

Д. Нямсурэн, Монголын сувилахуйн нийгэмлэгийн тэргүүн

Ц.Амаржаргал, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Сувилахуйн албаны дарга

Э.Өлзийсайхан, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн гэмтэл согог, мэс заслын тасгийн сувилагч

Н.Баасанжаргал, Улсын гуравдугаар төв эмнэлгийн сувилахуйн албаны арга зуйч

Г.Энхзаяа, Орхон аймгийн эрүүл мэндийн газрын сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Р.Эрдэнэсувдаа, Орхон аймгийн Бусийн оношилгоо, эмчилгээний төвийн Халдвартын тасгийн сувилагч

М.Оюунсайхан, Сувилахуйн үндэсний чиглуулэгч багш

А.Оюун-Эрдэнэ, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга

Г.Мягмарсурэн, Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн сургалт хариуцсан мэргэжилтэн

Г.Ганхуяг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн суурь сувилахуйн тэнхимийн эрхлэгч

Б.Амартүвшин, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол Японы эмнэлгийн Сувилахуйн сургалт хариуцсан захирал

Ямамото Ёоко, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) —ын Эмч болон сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн мэргэжилтэн

Б.Биндэръяа- Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) —ын Эмч болон сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн ажилтан

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн А/69 дугаар тушаалын Хавсралт 2

## Сувилахуйн эмнэл зүйн ур чадварын шатлал болон шинэ төгссөн сувилагчийн сургалтын удирдамж боловсруулах ажлын удирдамж

Үндэслэл:

Монгол Улсын Эрүүл мэндийн яам болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран "Эмч болон сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл"-ийг 2021 оны 1 дүгээр сараас эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд сувилахуйн цогц чадамжийг боловсруулж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.

Цаашид сувилахуйн төгсөлтийн дараах сургалтын чанарыг сайжруулах зорилгоор цогц чадамжид суурилсан сувилагч мэргэжилтнийг хөгжүүлэх эмнэл зүйн ур чадварын шатлал, шинэ сувилагчийн сургалтын удирдамжийг боловсруулах шаардлагатай юм. Ингэснээр сувилахуйн тусламж үйлчилгээний чанар сайжрах болно.

Зорилго:

Монгол Улсын онцлогт тохирсон сувилагчдын Эмнэл зүйн ур чадварын шатлал болон шинэ сувилагчийн сургалтын удирдамж боловсруулахад

Оролцогч байгууллага:

- Эрүүл мэндийн яам
- Эрүүл мэндийн хөгжлийн төв
  Сувилахуйн төрөлжсөн мэргэшлийн сургалт эрхлэгч байгууллага
  Төслийн загвар байгууллага (УХТЭ, Орхон БОЭТ)
- НЭМГ-ын харьяа эрүүл мэндийн байгууллага
- АШУУИС-ийн Сувилахуйн сургууль
- АШУУИС-ийн Монгол Японы сургалтын эмнэлэг
  Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) —ын төслийн нэгж

Сургалтын хугацаа:

2023 оны 8 дугаар сараас 2024 оны 10 дугаар сар

Сургалтаас хүлээгдэж буй ур дүн:

1. Монгол Улсын сувилагчийг хөгжүүлэхэд чиглэсэн Эмнэл зүйн ур чадварын шатлалын төслийг боловсруулсан байна.
2. Шинэ сувилагчийг бэлтгэхэд зориулсан сургалтын удирдамжийн төслийг боловсруулсан байна.

3, Эмнэл зүйн ур чадварын шатлал болон шинэ сувилагчид зориулсан сургалтын удирдамжийн төслийг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар танилцуулж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна.

АГУУЛГА


1. Үндэслэл
2. Зорилго, зорилт, шатлалыг ашиглах зорилго, шатлал гэж юу вэ?
3. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын тодорхойлолт, бүтэц
4. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын давуу талууд
5. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг нэвтрүүлэх зураглал
6. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх аргачлал
7. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын түвшинг үнэлэх аргачлал
8. Дүгнэлт
9. Ном зүй

Хавсралт 1: Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын хүснэгт

Хавсралт 2: Сувилахуйн ур чадварын үнэлгээний хуудас

# “СУВИЛАГЧ МЭРГЭЖИЛТНИЙ УР ЧАДВАРЫН ШАТЛАЛ”-ЫГ АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА

## *Нэг. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал боловсруулсан үндэслэл:*

Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн тогтолцооны үндсэн 6 гол баганын нэг болох эрүүл мэндийн салбарын ажиллагсад буюу хүний нөөц чухал үүрэг оролцоотой байдаг.

Өнөөдрийн байдлаар сувилагч мэргэжилтэн нь дэлхий нийтэд эрүүл мэндийн салбарын хамгийн том мэргэжлийн бүлэг бөгөөд эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн 59 орчим хувийг эзэлж буй сувилагч мэргэжилтний хувьд хомсдол, насжилт, нийгмийн хамгааллын дутмаг байдал, ажлын өндөр ачаалал, бага цалин зэрэг олон тулгамдсан асуудалтай нүүр тулсан байдалтай байна. (State of the World's Nursing 2020).

Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж , нийгмийн халамж хүний болон санхүүгийн нөөц хязгаартаа хүрч, олон төрлийн архаг өвчинтэй дасан зохицож амьдрахаас өөр аргагүй байдалтай хүмүүсийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж, түүнийг дагаад эмнэлгийн болон сувилахуйн тусламж үйлчилгээний хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдэж, илүү их төрөлжиж, ээдрээ төвөгтэй болж байна. Ийм нөхцөл байдалд Монголын нийгэм, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц хүний эрхийг дээдэлсэн ёс зүйн хандлага төлөвшсөн, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ болон асаргаа сувилгаа, нийгмийн байдлыг ойлгож хэрэгжүүлэх ур чадвартай, бүх шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллах сувилагч мэргэжилтнийг хүсэн хүлээж байгаа билээ. Гэсэн хэдий ч өнөөдрийг хүртэл сувилагч мэргэжилтний ажлын байран дээр өсөн дэвжиж, хөгжих системтэй тогтолцоо, нэгдсэн бодлого дутмаг байсны улмаас эмнэлгийн байгууллагууд өөр өөрийн түвшинд сувилагчийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалт, үнэлгээний арга аргачлалыг хэрэгжүүлж ирсэн хэдий ч энэ нь байгууллага бүрд харилцан адилгүй өөр өөр байна.

Сувилагч мэргэжилтний ур чадварыг үндэсний хэмжээнд нэгдсэн үзүүлэлтийг ашиглан бодитой үнэлж чадвал эмнэлгийн бүхий л байгууллагад сувилахуйн ур чадвар нэг түвшинд очих бөгөөд энэ нь сувилагч мэргэжилтэн төдийгүй эрүүл мэндийн байгууллагын сувилагч мэргэжилтний ур чадварыг зохистой, бодитой байдлаар харах боломжтой болж эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг найдвартай хангахад хүргэдэг. Мөн сувилагч мэргэжилтнүүдэд зориулсан ур чадварын хөгжлийн тогтолцоог болгох боломжтой юм.

Монгол улсын эрүүл мэндийн салбарт ажиллаж буй сувилагч мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог сайжруулах үйл ажиллагааны хүрээнд Япон улсын Жайка Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр сувилагч мэргэжилтний цогц чадамжийг боловсруулан гаргаж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан ба цаашдаа сувилахуйн гардан үйлдэлд суралцах арга хэрэгслийг боловсронгуй болгох, сувилагч мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэх, шинэ сувилагчийг ажлын байран дээр дадлагажуулан сургах сургалтын хөтөлбөр боловсруулах болон сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг шинээр боловсруулж, нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

## *Хоёр. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын зорилго, зорилт*

***Зорилго:***

Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэхийн тулд сувилагч мэргэжилтний цогц чадамжид үндэслэн гаргасан ур чадварын шатлалыг ашиглаж, сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх чадварыг үнэлж, ур чадвартай сувилагч мэргэжилтэн бэлтгэх.

***Зорилт :***

1. Сувилагч мэргэжилтний тусламж үйлчилгээ үзүүлэх ур чадварыг бодитой үнэлж, сувилагч өөрийгөө хөгжүүлэх, эрүүл мэндийн байгууллага нь дэмжлэг үзүүлэх эрх зүйн баримт бичиг болгон ашиглана.
2. Сувилагч мэргэжилтэн карьераа хөгжүүлэхийн тулд сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх ур чадвараа өөрөө үнэлэн, өөрийгөө хөгжүүлэх үүрэгтэй бөгөөд цогц ур чадварыг эзэмшихийг зорино.
3. Эрүүл мэндийн байгууллага нь сувилагчаа хөгжүүлэх үүрэгтэй бөгөөд, ур чадварын түвшинд тохируулан сурч боловсроход дэмжлэг үзүүлж, хүн амын хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлнэ.

### *Гурав. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал гэж юу вэ?*

Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад шаардагдах ур чадваруудыг үе шаттайгаар үнэлэн, хувь хүн бие даан хөгжих, байгууллага нь сувилагчийн ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тогтолцоо юм.

“Clinical Ladder” гэдэг үгийн орчуулга нь шууд утгаараа “эмнэлзүйн шат” гэсэн утгатай бөгөөд үе шаттайгаар зорилгодоо хүрч, өөрийн ур чадварын түвшинг дээшлүүлэх үйл явцыг шатаар өгсөхтэй адилтган үзсэн болно.

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг ашигласнаар сувилагч мэргэжилтэн өдөр тутмын сувилахуйн дадлага ур чадвараа эргэцүүлэн бодож, юуг сайн хийж байгаа, юуг илүү сайжруулах шаардлагатайг бодитойгоор үнэлнэ. Үнэлгээ дүгнэлт хийснээр хувь хүний  зорилго болон асуудлыг тодорхой болгож, түүнийг шийдвэрлэхэд чиглэсэн сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх боломжтой болно. Мөн карьераа хөгжүүлэхийн төлөө өөрийгөө үнэлэх болон чадавхжуулах хэрэгсэл болгон ашиглана.

Байгууллага нь сувилагчийн тусламж үйлчилгээ үзүүлэх ур чадварыг үнэлэх болон эргэн зөвлөгөө өгөх замаар сувилагчийн ур чадварын түвшинд тохируулан боловсролын дэмжлэг үзүүлэн, ур чадварыг хөгжүүлэх хэрэгсэл болгон ашиглах боломжтой.

### *Дөрөв. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын бүтэц*

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал нь ЭМС-ын 2023 оны А/451 дүгээр тушаалаар баталсан  “Сувилагч мэргэжилтний цогц чадамж” дээр суурилсан ба энэ нь таван цогц чадамж, ур чадварын таван түвшингээс бүрдэнэ. Сувилагч мэргэжилтний цогц чадамж гэдэг  нь сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах мэргэжлийн үнэ цэнэ, мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага бүхий хувь хүн болон багаар ажиллахад хамгийн үр дүнтэй байх ур чадварын цогц ойлголт юм.    (Зураг 1. Сувилагч мэргэжилтний цогц чадамж)




Зураг 1. Сувилагч мэргэжилтний цогц чадамж

***Монголын сувилагч мэргэжилтний 5 цогц чадамжийн тодорхойлолт болон түүний бүрэлдэхүүн***

- ***Мэргэжлийн үүрэг хариуцлагыг биелүүлэх чадвар***

***Тодорхойлолт:*** Сувилагч мэргэжилтний хувьд хариуцлагатай байж, ёс зүйг эрхэмлэн, хууль эрх зүйн хүрээнд сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадвар юм.

*Бүрэлдэхүүн хүчин зүйл:*

- Хариуцлага хүлээх чадвар - Өөрийн үзүүлж буй сувилахуйн тусламж үйлчилгээний явц үр дүн, гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээнэ
- Тусламж үйлчилгээний мэргэжлийн ёс зүйтэй үзүүлэх чадвар - Ёс зүйг баримтлан сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- Хууль эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллах чадвар – сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой хууль стандарт, зааврын дагуу тусламж үйлчилгээг үзүүлнэ.

- ***Сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх чадвар***

***Тодорхойлолт:*** Үйлчлүүлэгч бүрд тохирсон сувилахуйн тусламж үйлчилгээг сувилгааны үйл ажиллагаанд үндэслэн хэрэгжүүлэх чадвар юм.

*Бүрэлдэхүүн хүчин зүйл:*

- Хэрэгцээг тодорхойлох чадвар - Тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж сувилахуйн чухал асуудлыг нь эрэмбэлнэ.
- Асран сувилах чадвар – Сувилахуйн үйл ажиллагааны таван шатлалын дагуу сувилахуйн төлөвлөгөөг гаргаж, үйлчлүүлэгчийн биеийн байдалтай уялдуулан итгэлтэй харилцааг тогтоон тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- Шийдвэр дэмжих чадвар - Үйлчлүүлэгчийн соёл, үнэт зүйлд үндэслэн үйлчлүүлэгч өөрөө шийдвэр гаргахыг нь дэмжинэ.

- ***Багаар ажиллах чадвар***

***Тодорхойлолт:*** Ижил мэргэжилтэн болон бусад мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллаж, сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлийг харилцан хэлэлцэж ажил үүргийн хуваарилалт хийн тусламж үйлчилгээг хамтдаа үзүүлэх чадвар юм;

*Бүрэлдэхүүн хүчин зүйл:*

- Харилцааны чадвар - Байгууллагын алсын хараа, эрхэм зорилгыг ойлгож, ижил мэргэжилтэн, бусад мэргэжлийн хүмүүстэй харилцаж, шаардлагатай мэдээлэл санал солилцож ажиллана.
- Хамтран ажиллах чадвар - Ижил мэргэжилтэн болон бусад мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллаж, нөхцөл байдалд тохируулан ажил үүргийн дахин хуваарилалт хийж, баг дотроо харилцан бие биеэ дэмжин ажиллана.

- ***Менежмент, манлайллын чадвар***

***Тодорхойлолт:*** Сувилагч мэргэжилтний хувьд сувилахуйн тусламж үйлчилгээг багаар үр дүнтэй бүтээмжтэй үзүүлэхэд багийн гишүүний хувиар нөхцөл байдалд нийцүүлэн манлайлан оролцож менежмент хийх чадвар юм.

*Бүрэлдэхүүн хүчин зүйл:*

- Зохион байгуулах хяналт тавих чадвар – Сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх орчин нөхцөл хүний нөөцийг зохицуулна
- Аюулгүй байдлыг хангах чадвар - Сувилахуйн тусламж үйлчилгэг үзүүлэхдээ эрсдэл аюулгүй байдлыг харгалзан үзэж эрсдэлийн менежментийг хэрэгжүүлнэ.
- Байгууллагын гишүүний үүрэг гүйцэтгэх чадвар – Заан сургах, чиглүүлэх арга зүйг ашиглан сувилахуйн тусламж үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгч болон багийн үйл ажиллагаанд зохицуулалт хийнэ.

- ***Сувилахуйн мэргэшсэн байдлаа сайжруулах чадвар***

***Тодорхойлолт:*** Сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх чадвараа хөгжүүлэхийн зэрэгцээ сувилагч мэргэжилтний үнэ цэнийг үйлчлүүлэгч төдийгүй нийгэмд таниулах чадвар;

*Бүрэлдэхүүн хүчин зүйл:*

- Сувилагч мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх чадвар - Сувилахуйн тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж , шаардлагатай эмнэл зүйн сургалтыг явуулна.
- Нийгэмд хувь нэмэр оруулах чадвар – Нийгэмд сувилагч мэргэжилтний үнэ цэнийг таниулна.
- Сувилахуйн эмнэл зүйн ур чадварыг сайжруулах чадвар - Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулахад багаар хамтран ажиллана.
- Тасралтгүй суралцах чадвар - Өөрийн чадварыг хөгжүүлж тасралтгүй суралцана

### *4.2. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын түвшин*

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал нь сувилагч мэргэжилтний эзэмшсэн байх цогц чадамжид суурилан ур чадварын 5 түвшинд хуваагдана. Ур чадварын шатлал нь "Түвшин I"-ээс "Түвшин V" хүртэл байх ба түвшин ахих тусам ур чадвар дээшилж байгааг илэрхийлнэ. Түвшин бүрд “түвшин тус бүрийн зорилт”, түүнийг илэрхийлсэн “үйлдлийн зорилт”-ыг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл “түвшин тус бүрийн зорилго”-д хүрэхийн тулд хийх ёстой зүйл бөгөөд үйл ажиллагааны зорилгодоо хүрснээр түвшин бүрд хүрч чадна гэдгийг илэрхийлж буй юм.

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал нь сувилагчийн "ажилласан жил" бус "мэдлэг, ур чадвар, хандлага”-ыг чухалчилсан үнэлгээ юм. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын түвшин тус бүрийн тодорхойлолтыг доор үзүүлэв.

***Хүснэгт1: Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын түвшин бүрийн тодорхойлолт***

| *Түвшин* | *Тодорхойлолт* |
|---|---|
| ***Түвшин I*** | Сувилахуйн тусламж, үйлчилгээг зөвлөгөө авч стандартын дагуу үзүүлнэ. |
| ***Түвшин II*** | Сувилахуйн тусламж, үйлчилгээг бие даан стандартын дагуу үзүүлнэ. |
| ***Түвшин III*** | Тасаг нэгжийн онцлог, үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тохирсон сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлнэ |
| ***Түвшин IV*** | Сувилахуйн тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэхэд олон талаас нь үнэлж, шийдвэр гаргана. |
| ***Түвшин V*** | Үйлчлүүлэгчийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд нөхцөл байдалд тохирсон хамгийн тохиромжтой сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлж, бодлого шийдвэр боловсруулахад оролцоно. |

***Тав. Эмнэл зүйн ур чадварыг нэвтрүүлэх үндсэн санаа***

***5.1. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг өөрийгөө хөгжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах:***

Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хамгийн ойр үзүүлдэг мэргэшсэн хүний хувьд сувилагч мэргэжилтнээс насан туршдаа мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхийг шаарддаг. Тиймээс нийгмийн зүгээс хүсэн хүлээгдэж буй, мөн цаг үеийн нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж байгаа энэ үед түүнд тохирсон шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшихийн тулд сувилагч мэргэжилтэн өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх нь чухал байдаг.

Сувилагч мэргэжилтний хувьд энэхүү шатлалыг ашиглан өөрийн ур чадвараа үнэлнэ. Мэргэшсэн чадварлаг мэргэжилтэн болж өсөж хөгжихийн тулд одоогийн түвшингээ зөв ойлгож, ур чадвараа дээшлүүлэхийн тулд өөрийгөө сайжруулах бодитой арга, зорилго, зорилтуудыг ойлгомжтой байдлаар илэрхийлж харуулсан байгаа тул ур чадварын шатлалыг үр дүнтэй ашиглах боломжтой юм.

***5.2. Байгууллагын хувьд өөрийн алсын хараа, эрхэм зорилгодоо уялдуулан сувилагч мэргэжилтнээ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгсэл болгон ашиглах:***

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг Эрүүл мэндийн байгууллагууд өөрийн алсын хараа, эрхэм зорилго, чиг үүрэг, цар хүрээнд тулгуурлан сувилагч мэргэжилтнээ хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэрэгсэл болгон ашиглах боломжтой. Сувилагчдын ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхийн тулд тухайн эмнэлгийн байгууллагад ур чадварын шатлалын тогтолцоонд тулгуурласан сургалтын тогтолцоог бий болгон хөгжүүлж, дэмжин ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалд тулгуурласан сургалтын тогтолцоог бий болгосноор сувилагчдын ур чадвар дээшлэн, байгууллагын хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар сайжирна. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг сургалтын тогтолцооны тулгуур багана гэж ойлгон, байгууллага бүр өөрийн алсын хараа, эрхэм зорилго, чиг үүрэг, цар хүрээнд тохируулан нэвтрүүлж, үр дүнтэй ашиглах нь зөвхөн сувилагч мэргэжилтэнд төдийгүй тухайн эрүүл мэндийн байгууллагад чухал ач холбогдолтой юм.

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг нийтлэг үзүүлэлт болгон бүх шатны эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлснээр өвчлөл хүндрэлээс урьдчилан сэргийлэх, өвчний цочмог үеэс эхлээд архаг үе шат хүртэлх бүхий л үе шатанд сувилахуйн тусламж үйлчилгээг тасралтгүй нэг түвшинд үзүүлэх боломж бүрдэнэ.

***Зургаа. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг ашиглах давуу талууд***

- *Сувилагчийн ур чадварыг бодитойгоор үнэлнэ.*
  Ур чадварын шатлал нь сувилагчийн ур чадварыг бодитойгоор үнэлэх боломжийг олгодог учраас сувилагч өөрийнхөө одоогийн түвшин болон зорилтот түвшнээ зөв тодорхойлох боломжтой болно. Сувилагч болон сургаж буй талууд ижил үнэлгээний системийг ашиглан бодитой үнэлгээ хийх боломжийг бүрдүүлж байгаа нь давуу тал болно.

- *Зорилгыг тодорхой болгоно.*
  Ур чадварын шатлалын үнэлгээний үе шат нь "түвшин ахих схем зураглал" -тай. Ур чадварын шатлал нь 5 түвшинд хуваагдаж, тодорхой чадваруудыг түвшин тус бүрээр харуулдаг тул богино, дунд, урт хугацааны зорилго тавьж, ур чадвараа тасралтгүй хөгжүүлж, түвшингээ ахиулах боломжтой. Өөрөөр хэлбэл зорилго нь тодорхой гарч ирснээр дараагийн хүрэх түвшин ба түүнд хүрэх зорилтуудыг ойлгож, өөрийгөө сайжруулах шалгуур болно.

- *Урам зоригийг нэмэгдүүлнэ.*
  Хүрэх түвшин, зорилгоо тодорхой болсноор "ур чадвараа дээшлүүлэх" хүсэл эрмэлзэл, урам зоригийг бий болгодог ба энэхүү ур чадварын шатлалыг “зөвхөн түвшингээр ангилах хэрэгсэл” бус харин “мэргэжилтний хувьд ур чадвараа хөгжүүлэх хэрэгсэл”' гэж ойлгох нь чухал юм.

- *Өөрийн ур чадвараа тодорхой харуулах боломж бүрдэнэ.*
  Ур чадварын шатлалыг нэвтрүүлэн, хэрэгжүүлж эхэлснээр сувилагчийн ажиллах тасаг нэгж, ажлын байр өөрчлөгдсөн ч өөрийнхөө түвшин, ур чадвараа бодитой харуулах боломжтой. Өөрөөр хэлбэл: хаана ажиллаж байгаагаас үл хамааран эмнэлгийн байгууллага дотооддоо, мөн аль ч эмнэлгийн байгууллагад сувилагчийн ур чадварыг тодорхой байлгах, түүнийг сайжруулах гол хэрэгсэл болох давуу талтай.

- *Эрүүл мэндийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанд сайнаар нөлөөлнө.*
  Ур чадварын шатлалаар үнэлгээ хийхдээ ихэвчлэн эмнэлгийн тасаг нэгжийн ахлах сувилагч, туршлагатай зөвлөх сувилагч, чиглүүлэгч, сургагч багш нартай ярилцлага хийх үед ашиглах боломжтой. Сувилагчийн хувьд сургагч багш нартайгаа шатлалын түвшинг ярилцсанаар өдөр тутмын ажилд орхигдох магадлалтай өөрсдийн чиг үүрэг, цаашдын зорилгоо дахин баталгаажуулж, сургагч багш нар сувилагчийнхаа зорилгын дагуу зохистой үнэлгээг хийнэ.
  Сувилагчийнхаа ур чадварыг хөгжүүлж, чадамж бүхий сувилагчтай байх нь сувилахуйн тусламж, үйлчилгээ чанар сайжирч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нэмэгдэнэ. Мөн сувилагч нарынхаа сургалт, хөгжилд дэмжлэг үзүүлэх нь тэднийг ажлаас гарах хувийг бууруулах, эмнэлгийн урт хугацааны үндсэн үйл ажиллагаанд сайнаар нөлөөлнө.

## *Долоо. "Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал"-ыг байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх арга*

### *"Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал"-ыг байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх үйл ажиллагаа:*

1. Байгууллага нь ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулна.
2. Ажлын хэсэг нь хэсгийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлж, эмнэлзүйн ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргана.
3. Байгууллагын хэмжээнд нийт албан хаагчдад ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх танилцуулга хийнэ.
4. Байгууллагынхаа алсын хараа, эрхэм зорилго, сувилахуйн тусламж, үйлчилгээний онцлогт тохируулан сувилагчийн дүр төрхийг тодорхойлно.
5. Өөрийн байгууллагын ур чадварын шатлалын загвар боловсруулна. Ур чадварын шатлалын загварыг боловсруулахдаа удирдлагын баг болон эмч, сувилагч мэргэжилтнүүдээс санал авах, хэлэлцүүлэг хийх зэрэг арга хэмжээг зохион байгуулна.
6. Өөрийн байгууллагы ур чадварын шатлалын загварыг удирдлагын багт танилцуулан, байгууллагын захирал (дарга)-аар батлуулна.
7. Батлагдсан ур чадварын шатлалыг байгууллагын бүх гишүүдэд танилцуулна.
8. Цаашид сувилахуйн алба нь батлагдсан ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэн ажиллана.

**Хүснэгт2. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх үйл явцын зураглал**

| Нэвтрүүлэх явц | Хариуцагч |
|---|---|
| Байгууллага нь сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах ба ажлын хэсгийн гишүүдийн үүрэг хариуцлагыг тодорхойлон, ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргана. | Сувилахуйн алба |
| Байгууллагын эрхэм зорилго алсын хараа, байгууллагынхаа онцлогт тохируулан байгууллагынхаа сувилагчийн дүр зураг, сувилагчийн ур чадварыг тодорхой болгоно. | Байгууллагын удирдлага、сувилахуйн алба |
| Өөрийн байгууллагын онцлог, үйл ажиллагааны цар хүрээнд тохируулан ур чадварын шатлалыг боловсруулан, батлах | Байгууллагын удирдлага, сувилахуйн алба |
| Байгууллагынхаа бүх албан хаагчиддаа танилцуулж, нэвтрүүлэх төлөвлөгөөг гарган ажиллана. | Сувилахуйн алба |

## *Найм. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг хэрэгжүүлэх аргачлал*

### *8.1. Сувилагч мэргэжилтний түвшинд*

- Монгол улсын сувилахуйн цогц чадамжид суурилсан “Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал”-ийг сувилагч бүр өөрийн мэргэжлийн ур чадвараа үнэлэх, ойрын болон хэтийн зорилгоо төлөвлөн өөрийгөө сайжруулах хөгжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглана.
- Сувилагч бүр ур чадварын шатлалын түвшин бүрийн хүрэх үр дүн, үйлдлийн зорилгоо тодорхой болгож, түүнд хүрэхийн тулд юуг сурч, ямар туршлага хуримтлуулах ёстой, ямар дэмжлэг авах боломжтойг олж харж, өөрийн өсөлт хөгжилтийн зорилгыг удирдан ажиллана.
- Өөрийн үнэлгээг, хөндлөнгийн үнэлгээтэй харьцуулан бодитоор үнэлж өөрийнхөө үнэлэмжийг нэмэгдүүлэхэд хариуцлагатай хандана.
- Ур чадварын шатлалын түвшин ахиулахад зайлшгүй шаардлагатай мэдлэг болон ажиллангаа суралцах (OJT) сургалтад тасралтгүй хамрагдах, эрдэм шинжилгээ, судалгаа хийж нотолгоонд суурилсан сувилахуйн мэдлэг, ур чадвараа хөгжүүлэхэд санаачлагатай ажиллана.

### *8.2. Сувилахуйн албаны түвшинд*

- Ур чадварын шатлалыг байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх, хэрэгжилтийг ханган ажиллахад санаачилгатай, манлайлалтай ажиллана.
- Байгууллагын сувилагч бүрийн ур чадварын шатлалын түвшний хүрэх үр дүн, үйлдлийн зорилго, зорилтыг тодорхойлж, түвшин ахиулах, мэдлэг чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Түвшин ахиулах явцын үнэлгээг үнэн зөв, бодитой хийх, сувилагч бүрийг зорилгодоо хүрсэн эсэхийг нягталж зөвлөгөө өгч, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Ур чадварын шатлалын түвшин бүрд зайлшгүй шаардлагатай мэдлэг, дадлага олгох ажлын байрны сургалтын нарийвчилсан төлөвлөгөөг гарган, сурах орчин нөхцөл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхэд дэмжлэг үзүүлнэ.

### *8.3. Байгууллагын удирдлагын түвшинд*

- Ур чадварын шатлалыг хэрэгжүүлэхэд байгууллагын хэмжээнд удирдлагын зүгээс дэмжиж ажиллана.
- Эрүүл мэндийн байгууллага нь сувилагчийнхаа ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, үнэлэх тогтолцоог бий болгож, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.
- Эрүүл мэндийн байгууллага нь өөрийн байгууллагын онцлогт тохируулан, боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллахад санаачилгатай ажиллана.
- Ур чадварын шатлалыг нийтлэг үзүүлэлт болгон ашиглан, шатлалд тулгуурлан сургалтын үйл ажиллагааг төлөвлөн явуулна.
- Ур чадварын шатлалыг гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулж, цалин хөлс, нийгмийн хамгааллыг сайжруулахад санаачилга гарган ажиллана.
- Түвшин ахиж буй сувилагч нарт байгууллагын зүгээс гэрчилгээ олгож, баталгаажуулах, урам өгөх үйл ажиллагааг санаачлан ажиллана.

***Ес. Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын түвшнийг үнэлэх аргачлал:***

Ур чадварын шатлалын үнэлгээг түвшин бүрийн зорилгод үндэслэн хийнэ.

***9.1.Үнэлгээний зорилго***

- Үнэлгээ нь сувилагчийн өөрийн чадвартаа итгэх итгэлийг нэмэгдүүлэх , хэрхэн өсөж дэвжиж байгааг нь ойлгуулах, урам зориг өгөх, бие даасан үйл ажиллагааг дэмжих, цаашид түвшин ахих, ур чадвараа сайжруулахад эргэн зөвлөгөөг эергээр өгч, ур чадварыг тэнцвэртэй хөгжүүлэх зорилготой.
- Байгууллага нь ур чадварын шатлалд тулгуурласан сургалтын чанар үр дүнг үнэлэн цаашид гарч болзошгүй асуудлуудыг тодорхойлон илүү сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

***9.2. Хэрхэн үнэлэх***

Үнэлгээг бодитой хийх үүднээс сувилагчийн өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээг хамт хийнэ.

- Өөрийн үнэлгээ гэдэг нь сувилагч өөрөө өөрийхөө ур чадварыг үнэлэн дүгнэж, сайн чаддаг болон бэрхшээлтэй байгаа асуудлаа тодорхойлж, цаашид суралцах хэрэгцээгээ өөрөө гаргаж ирэх үйл явц юм.
- Хөндлөнгийн үнэлгээ гэдэг нь сувилагч өөрийн үнэлгээгээ хийсний дараа дахин үнэлгээ хийж, харилцан ярилцаж, зөвлөлдөн, дэмжлэг үзүүлэх үйл явц юм.

Хөндлөнгийн үнэлгээг хийхэд туршлагатай сувилагч, тасгийн ахлах сувилагч, сургагч болон чиглүүлэгч багш, сувилахуйн албаны арга зүйч зэрэг 2 дээш мэргэжилтнийг оролцуулж, үнэлгээний нэгтгэл, үр дүнг сувилахуйн албанд тайлагнана.

Сувилахуйн алба нь үнэлгээний үр дүнг харгалзан сургалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийж, тохирсон сургалтыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

***9.3.Үнэлгээний хугацаа***

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын түвшинд хүрсэн байдлыг дүгнэхдээ дараах хугацааг жишиг байдлаар ашиглах боломжтой.

- Түвшин I буюу шинэ сувилагчийн ур чадварыг жилд 4 удаа үнэлэх
  Тухайлбал: ажилд орох үед, 3 сарын дараа, 6 сарын дараа, 12 сарын дараа,
- Түвшин II-IV-ийн сувилагчийн үнэлгээг жилд 1 удаа гэх мэт тухайн байгууллага нь өөрийн онцлогт тохируулан үнэлгээний хугацааг тодорхойлно.

***9.4. Үнэлгээний агуулга***

Жишиг үнэлгээний хуудсаар түвшин тус бүрийн хүрэх зорилго, үйлдлийн зорилтыг нэгдсэн дүнгээр үнэлнэ. /Хавсралт 2 хүснэгтээр харуулав/

Дараах байдлаар 3 түвшний үнэлгээний хэмжүүр ашиглан үнэлнэ.

***Хүснэгт 3. Үнэлгээний хэмжүүрийн жишээ:***

| ҮНЭЛГЭЭ | | АГУУЛГА |
|---|---|---|
| Бүрэн чадна | 5 | Өөрөө хэрэгжүүлж чадна |
| Дэмжлэгтэй чадна | 3 | Бусдын дэмжлэгтэй чадна |
| Чадахгүй | 0 | Өөрөө хэрэгжүүлж чадахгүй |

***Нийт оноо 80% дээш үнэлгээ авсан тохиолдолд тухайн түвшний зорилгодоо хүрсэн гэж үзнэ. 80% доош үнэлгээ авсан тохиолдолд сургагч багш, сувилахуйн албатай ярилцан цаашдын зорилго төлөвлөгөөг тодорхойлон, дэмжлэг үзүүлэн ажиллана.***

***Арав. Үр дүн, дүгнэлт:***

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлал нь цогц чадамжид суурилсан ба бүх шатны эрүүл мэндийн байгууллагын сувилагч мэргэжилтэнд нийтлэг байх ажиллангаа тасралтгүй суралцаж, ур чадвараа хөгжүүлэх, суралцахад дэмжлэг үзүүлэх, бодитой үнэлэх, улмаар өвчтөн, үйлчлүүлэгчид чанартай сувилахуйн тусламж, үйлчилгээг үзүүлэх зорилгоор боловсруулж, нэвтрүүлэхийг зорьж байна.

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалыг үндэсний хэмжээнд нэвтрүүлснээр хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц үйлчлүүлэгчийн эрхийг дээдэлсэн ёс зүйн хандлага төлөвшсөн, нийгмийн эрүүл мэнд, нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх сувилагч мэргэжилтний ур чадварыг тасралтгүй хөгжүүлснээр бүх шатны эрүүл мэндийн байгууллагад сувилагчийн ур чадвар ижил түвшинд очно.

Сувилагч мэргэжилтний ур чадварын шатлалын үр дүнг тодорхой хугацаанд үнэлэн дүгнэж, сайжруулалт хийж байх шаардлагатай.

**Түвшин тус бүрийн хүрэх зорилго ба үйлдлийн зорилтыг үнэлэх үнэлгээний жишиг хуудас**

**1. Мэргэжлийн үүрэг хариуцлагыг биелүүлэх чадвар:** Сувилагч мэргэжилтний хувьд хариуцлагатай байж, ёс зүйг эрхэмлэн, хууль эрх зүйн хүрээнд сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх чадвар юм.

| **Бүрдүүлэх хүчин зүйл** | **Түвшин** | **Түвшин Ⅰ** | **Түвшин Ⅱ** | **Түвшин Ⅲ** | **Түвшин Ⅳ** |
|---|---|---|---|---|---|
| | **Түвшин бүрийн тодорхойлолт** | Сувилахуйн тусламж үйлчилгээг зөвлөгөө авч стандартын дагуу үзүүлнэ. | Сувилахуйн тусламж үйлчилгээг бие даан стандартын дагуу үзүүлнэ. | Тасаг нэгжийн онцлог, үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тохирсон сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлнэ. | Сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхэд олон талаас нь үнэлж шийдвэр гаргана. |
| **Хариуцлага хүлээх чадвар** | **Түвшин бүрийн зорилго** | Сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ хийж буй үйлдлээ тайлбарлан, өөрийн чадвар, үүргээ ухамсарлан зөвлөгөө авч хариуцлагатай ажиллана. | Сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ тайлбар өгч хариуцлагатайгаар бие даан үзүүлнэ. | Тасаг нэгжийн онцлог, үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тохирсон сувилахуйн тусламж үйлчилгээг багаараа хамтран хариуцлагатай үзүүлнэ. | Сувилахуйн тусламж үйлчилгээг чанартай үзүүлэхэд байгууллагын түвшинд асуудлыг олон талаас нь харж, шийдвэр гарган эрсдлийг урьдчилан таамаглаж хариуцлагатай ажиллана. |
| | **Үйлдлийн зорилт** | • Сувилагчийн эрх үүрэг, хүлээх хариуцлагын талаар танилцан ойлгож чадна.<br>• Өөрийн гаргасан шийдвэр, хийх үйлдэлдээ тайлбар хийж, харилцан ойлголцож чадна.<br>• Сувилахуйн үйл ажиллагааны зорилгыг ойлгон, өөрийн үзүүлсэн сувилахуйн тусламж үйлчилгээний тэмдэглэлийг хийж чадна.<br>• Өөрийн үйл ажиллагаа, үйлдлийн үр дүнд хариуцлага хүлээж чадна. | • Бие даан гаргасан шийдвэр хийсэн үйлдлээ зохистой тайлбарлан харилцан ойлголцож чадна.<br>• Бие даан үзүүлсэн сувилахуйн тусламж үйлчилгээний тэмдэглэлийг зохистой хөтөлж чадна.<br>• Өөрийн үйл ажиллагаа, үйлдлийн үр дүнд хариуцлага хүлээж чадна. | • Үзүүлсэн сувилахуйн тусламж үйлчилгээний тухай багаараа ярилцаж чадна.<br>• Хувь хүнд үзүүлсэн сувилахуйн тусламж үйлчилгээний тухай түүний ар гэрийнхэнд тайлбарлан хариуцлага хүлээж чадна.<br>• Шаардлагатай үед зөвлөгөө, зөвлөмж өгч чадна.<br>• Тасаг /Нэгжид үзүүлж буй сувилахуйн тусламж үйлчилгээний үр дүнд хариуцлага хүлээж чадна. | • Өргөн хүрээнд байгууллагын түвшинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд оролцон алдаа эрсдэлээс сэргийлж чадна.<br>• Асуудал болон эрсдэлийг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч чадна.<br>• Байгууллагын хэмжээнд үзүүлж буй сувилахуйн тусламж үйлчилгээнд хариуцлага хүлээж чадна. |
